

ЦАЛИН УРАМШУУЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ЖУРАМ

Нэг. ЗОРИЛГО

- 1.1. ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо цаашид “Хороо” гэх)-ны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийг дараахь үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино. Үүнд:
 - 1.1.1. ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Эрх бүхий албан албан тушаалтнуудын (Санхүү бүртгэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирал, дотоод аудитор, салбарын захирал, эрсдэлийн ажилтан) цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, компанийн хэмжээнд цалин, урамшууллын бодлогыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих
 - 1.1.2. ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Эрх бүхий тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх

Хоёр. ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- 2.1. Хороо нь 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд хорооны гишүүдийн 1-ээс доошгүй нь хараат бус ТУЗ-ийн гишүүн байна.
- 2.2. Хорооны даргыг хорооноос санал болгож, ТУЗ-ийн хурлаар, ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар томилно.
- 2.3. Хорооны дарга, гишүүд нь дараагийн дарга, гишүүд албан ёсоор томилогдож, ТУЗ-өөс хорооны гишүүнээс чөлөөлөх шийдвэр гартал хорооны гишүүний ажил үүргээ гүйцэтгэнэ.
- 2.4. Зөвхөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Хорооны гишүүнээр сонгогдох эрхтэй

Гурав. ХОРООНЫ ХУРАЛ

- 3.1. Хорооны үйл ажиллагаагаа явуулах үндсэн хэлбэр нь хурал байна.
- 3.2. Хорооны хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Ээлжит хурлыг хагас жилд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай нөхцөлд ээлжит бус хурлыг хэдийд ч хуралдуулж болно.
- 3.3. Хуралд гишүүдийн 2/3 оролцсоноор хүчин төгөлдөр болох ба гишүүд хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хурлыг гишүүд харилцан бие биенээ сонсож, санал бодлоо илэрхийлж болох арга хэрэгслийг ашиглан утсаар эсвэл видео хэлбэрээр зохион байгуулах эсвэл хуралд оролцоогүй гишүүний саналыг бичгээр авсан байж болно. Хорооны хуралд шаардлагатай тохиолдолд компанийн удирдлагууд болон ажилтнууд, гаднын зөвлөгчдийг оролцуулж болно.

- 3.4. Хорооны дарга нь хорооны хурлын тов, хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлох, хурал даргалах бөгөөд гишүүдийн зүгээс хэлэлцэх асуудалд оруулах саналаа хурал хуралдахаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө ирүүлж болно.
- 3.5. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, материалыг урьдчилан гаргуулж, бүх гишүүд танилцсаны үндсэн дээр хэлэлцүүлэг явагдана.
- 3.6. Хороо нь хурлаар хэлэлцсэн асуудлынхаа хүрээнд дүгнэлт, зөвлөмж, шийдвэр гаргаж, холбогдох дүрэм, журмыг батална.

Дөрөв. ХОРООНЫ ҮҮРЭГ

4.1. Цалин урамшууллын бодлого тодорхойлж, хяналт тавих үүргүүд:

- 4.1.1. Компанийн орон тоо, цалин, урамшууллын асуудлыг хэлэлцэх, санал, дүгнэлтээ ТУЗ-д танилцуулж шийдүүлэх, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих
- 4.1.2. Компанийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд, түлхүүр ажилтнуудын цалин, урамшууллын талаар санал гаргах ТУЗ -д танилцуулж батлуулах
- 4.1.3. Жил бүрийн орон тоо, хүний нөөцийн зардалтай холбоотой төсөв, цалингийн сүлжээний төсөлд санал дүгнэлт гаргах, ТУЗ-д танилцуулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих
- 4.1.4. Компанийн хүний нөөцийн бодлогын бичиг баримт, хөдөлмөрийн дотоод журам, ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх журам зэрэг хүний нөөцтэй холбоотой заавар журмыг хуульд нийцүүлэн боловсронгуй болгох, зөвлөмж чиглэл өгөх
- 4.1.5. Компанийн ажилтнуудын нийгмийн халамж, тогтвор суурьшлыг сайжруулах чиглэсэн бодлогыг тодорхойлоход зөвлөмж чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;
- 4.1.6. Компанийн цалин урамшууллын шийдэл нь байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, стратегийн төлөвлөгөөний хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

4.2. Нэр дэвшүүлэх үйл ажиллагаатай холбоотой үүргүүд:

- 4.2.1. ТУЗ-ийн гишүүн, хараат бус гишүүн, гүйцэтгэх захирал болон эрх бүхийн албан тушаалтанд тавигдах мэдлэг ур чадварын шаардлагыг тодорхойлох, сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэх
- 4.2.2. ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудын ажил үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг боловсрол, ажлын туршлага, ур чадвар, хувь хүний зан чанарын болон хараат бус байдлын шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, тус шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, ТУЗ болон ХЭХ-д танилцуулах
- 4.2.3. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлох, гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах санал боловсруулж, ТУЗ-д танилцуулах
- 4.2.4. Гүйцэтгэх захирал болон эрх бүхий албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих

Тав. ХОРООНЫ ЭРХ МЭДЭЛ

- 5.1. Компанийн хэмжээнд баримтлах Нэр дэвшүүлэх бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх талаар ТУЗ-д санал, зөвлөмж өгөх
- 5.2. Компанийн ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын хэмжээг тодорхойлох;
- 5.3. Компанийн хэмжээнд баримтлах цалин, урамшууллын бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх талаар компанийн удирдлагад үүрэг даалгавар, заавар зөвлөмж өгөх;
- 5.4. ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх
- 5.5. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- 5.6. Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангуулах, шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримтыг саадгүй гаргуулах
- 5.7. Хөндлөнгийн зөвлөх, мэргэжилтнээс зөвлөгөө, үйлчилгээ авах;
- 5.8. Хороо нь чиг үүргийнхээ хүрээнд шийдвэр гаргах, шаардлагатай бол ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлэх
- 5.9. Хорооны шийдвэртэй холбоотой ашиг сонирхлын зөрчил, хараат бус байдалд хяналт тавих

Зургаа. ТАЙЛАГНАЛ

- 6.1. Хороо нь үйл ажиллагаагаа ТУЗ-д жилд нэгээс доошгүй удаа тайлагнаж, шаардлагатай асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдүүлэх;
- 6.2. Компанийн цалингийн бодлого, түвшин, бүтэц, цалин тогтоох журмын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх;
- 6.3. Компанийн нийт цалин, урамшуулал, хөдөлмөрийн зардалтай холбоотой тайланг жил бүр хянан хэлэлцэж, ТУЗ-ийн хурал болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;

Долоо. КОМПАНИЙН НУУЦЫГ ХАДГАЛАХ

- 7.1. Хорооны гишүүд нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн зүгээс танилцуулсан аливаа нууц болон дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх, шууд болон шууд бус байдлаар бусдад задруулахгүй байх, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.

Найм. ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 8.1. Хороо нь энэхүү дүрмийн заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТУЗ-д санал оруулж батлуулна.

**Хөгжил Финанс ББСБ-ын ТУЗ-ын
23/15 тоот тогтоолын хавсралт №3**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ